



ХҮРТЭЭМЖТЭЙ ӨСӨЛТ БА ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС

С.Билгүүнзул¹, Б.Хулан²

Хураангуй: Хүртээмжтэй өсөлтийг нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт болон орлогын тэгш хуваарилалтын өсөлт аль, аль нь хангагдах нөхцөл гэж ойлгож болох ба хүртээмжтэй өсөлтөд эдийн засгийн өсөлт чухал боловч эдийн засаг өсөхийн зэрэгцээ өсөлтийг нийгмийн бүлгүүдэд тэгш хуваарилах, хүмүүсийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх нь чухал юм. Манай орны 1998-2018 онуудын дундаж хүртээмжтэй өсөлтийг тооцоход 5.1 хувь байсан бөгөөд эдийн засаг 2011-2018 онд жилд дунджаар 6.9 хувиар өргөжсөн ч хамгийн бага орлоготой 40% иргэдийн дундаж орлого ердөө 1 хувиар нэмэгдсэн байгаа нь хүртээмжтэй өсөлт сул байгаагийн илрэл юм. Улмаар хүртээмжтэй өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлсийн хувьд үнэлгээний голлох үр дүнгээс дурдвал хүртээмжтэй өсөлтөд инфляцын түвшин, орлогын дахин хуваарилалт, санхүүгийн гүнзгийрүүлэлт буюу хувийн хэвшилд олгосон дотоодын зээлийн ДНБ-д эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүд сөргөөр, гадаадын шууд хөрөнгө оруулалт болон гадаад худалдааны нээлттэй байдал зэрэг нь эергээр нөлөөлдөг байна. Иймд мөнгөний бодлогоор дамжуулан үнийн тогтвортой байдлыг хангах, манай оронтой төстэй бусад улсын туршлагыг судлан өөрт тохирсон орлогын дахин хуваарилалтын оновчтой бодлого боловсруулах нь хүртээмжтэй өсөлтийг хангахад чухал ач холбогдолтой.

Түлхүүр үгс: *Хүртээмжтэй өсөлт, эдийн засгийн өсөлт, тэгш бус байдал, орлогын тэгш хуваарилалт*

JEL ангилал: *F43, D63, O11, O47.*

¹ Монголбанк, Судалгаа, Статистикийн газар, Судалгааны хэлтэс, Ахлах эдийн засагч.
Цахим хаяг: bilguunzul@mongolbank.mn

² Монголбанк, Судалгаа, Статистикийн газар, Судалгааны хэлтэс, Эдийн засагч.
Цахим хаяг: khulan.b@mongolbank.mn

I. Удиртгал

Дэлхийн эдийн засаг хурдтай өсөхийн хэрээр хүртээмжтэй өсөлтийн талаарх асуудлуудад илүү анхаарч эхэлж байна. Аливаа улс орны эдийн засгийн өсөлт нь хэр хүртээмжтэй байгааг эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангахад хүн бүр оролцож, үр шимийг нь хүртэх тэгш боломжоор хангагдсан эсэхээр тодорхойлох боломжтой байдаг. Сүүлийн жилүүдэд дан ганц эдийн засгийн өсөлт хангалттай бус, түүний хүртээмжтэй байдлыг бодлого боловсруулагчид давхар авч үзэх нь нэн чухал гэдгийг онцолсоор байна.

Дэлхий нийтээр цар тахлын үеийн эдийн засгийн хүндрэлд нийгмийн эмзэг бүлгүүд илүү өртөж байгаа нь эдийн засгийн өсөлтийн хүртээмжтэй байдлын ач холбогдлыг улам тодотголоо. Манай улсын хувьд хамгийн бага орлоготой иргэд болон жижиг дунд үйлдвэр эрхлэгчид хямралд илүү өртөж байна (ТМБТБҮЧ, 2022). Иймд 2022 оны Үндсэн чиглэлийн 2 дугаар заалтын 1-т “Эдийн засгийн сэргэлтийг дэмжих, өсөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөв, мөнгө, санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх” гэж заасан байна.

Эдийн засгийн өсөлтийн хүртээмжтэй байдлын талаар дотоодод цөөн тооны судалгааны ажлууд хийгдсэн бөгөөд хүртээмжтэй өсөлтийг илэрхийлж болох ядуурлын түвшин, тэгш бус байдал, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, боловсролын чадвар, санхүүгийн хүртээмж зэрэг үзүүлэлтүүдийн нөхцөл байдлыг тоймлон харуулсан байсан тул энэхүү судалгаагаар (i) хүртээмжтэй өсөлтийн тодорхойлолт, түүнийг хэмжих талаар нэгдсэн ойлголтод хүрэх, (ii) хүртээмжтэй өсөлт түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг хэрхэн тооцсон бусад орнуудын туршлага судлах, (iii) хүртээмжтэй өсөлтийг илэрхийлэх нэгдсэн үзүүлэлт тооцох, (iv) түүнд нөлөөлөх макро болон бодлогын хүчин зүйлсийг тодорхойлохыг зорилоо.

Хүртээмжтэй өсөлтийн олон талт өнцгийг тусгасан, нэгдсэн нэг тодорхойлолт хараахан байхгүй байна. Иймд судалгааны ажлын дараагийн бүлгүүдэд хүртээмжийн өсөлтийн талаарх ерөнхий ойлголт, түүнийг хэрхэн хэмжих, хүртээмжийн өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлсон голлох судалгааны ажлын үр дүнг дурдах болно. Харин үлдсэн хэсгүүдэд судалгаанд ашигласан тоон мэдээлэл, эмпирик шинжилгээний үр дүнгүүд болон судалгааны ажлыг нэгтгэн дүгнэнэ.

II. Хүртээмжтэй өсөлтийн талаарх ойлголт

Хүртээмжтэй өсөлт нь энгийн мэт боловч нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт байхгүй, харьцангуй утопи сэдэв юм. Олон улсын түвшинд тухайн улсын хөгжил, ард иргэдийн амьдрах нөхцөл, амьдралын чанарыг илэрхийлэхэд


хүртээмжтэй өсөлтийг чухалчлах болсон хэдий ч нийгэм, эдийн засгийн олон талт байдлыг тусгасан цогц ойлголт учраас дэлхийн улс орнууд, олон улсын байгууллагууд нэгдсэн нэг тодорхойлолтод хүрэхэд хүндрэлтэй байсаар байна.

Олон улсын байгууллагууд хүртээмжтэй өсөлт явагдсанаар ядуу бүлгийн амьжиргааг дээшлүүлж, ядуурлыг бууруулна (*pro-poor growth*) гэж үздэг. Энэ ойлголт нь абсолют болон харьцангуй хоёр тодорхойлолтоор илэрхийлэгдэнэ.

1. Абсолют тодорхойлолтоор хүртээмжтэй өсөлт нь **зөвхөн ядуурлыг бууруулах** гэсэн ойлголтоор хязгаарлагддаг бөгөөд энэ нь бодит байдалд биелэх боломжгүй.
2. Харьцангуй тодорхойлолтоор хүртээмжтэй өсөлтийг ядуу, дундаж, чинээлэг гэж ялгаварлахгүйгээр нийгмийн бүхий л давхаргын амьдралын чанарыг дээшлүүлэх, ялгаатай байдлыг бууруулах өсөлт гэж үздэг.

Хүртээмжтэй байдлын бодит өсөлт буюу орлогод суурилсан үзүүлэлтүүдийг харуулахад туйлын ойлголт ашиглах тохиолдлууд байдаг ч ихэвчлэн олон улсын байгууллагууд болон судлаачид харьцангуй ойлголтоор илэрхийлэх нь зүйтэй гэж үздэг. Тухайлбал, хүртээмжтэй өсөлтийг McKinsey (2021) эдийн засгийн өсөлт болон түүний хуваарилалт нь нийт хүн амын амын орлогын бүх түвшинд жигд өсөлт ажиглагдсан үед үүсдэг хэмээн итгэдэг (Зураг 1).

Зураг 1. Хүртээмжтэй байдал болон эдийн засгийн өсөлт



Эх сурвалж: McKinsey, 2021

Өөрөөр хэлбэл, хүртээмжтэй өсөлтөд эдийн засгийн өсөлт чухал боловч өсөлтийн үр өгөөжийг хувь хүн болон нийгмийн бүлгүүдэд тэгш хуваарилахгүй бол тогтвортой хөгжлийг хангахгүй, үүний зэрэгцээ хүмүүсийн сайн сайхан байдалд орлогоос бусад үзүүлэлтүүд чухал нөлөө үзүүлдэг гэж үздэг байна.

Томоохон олон улсын байгууллагууд хүртээмжтэй өсөлтийг тэгш боломж, тэнцвэрт байдал гэж ерөнхийд нь авч үздэг ба өөрсдийн судалгаа, шинжилгээ болон стратегийн баримт бичгүүддээ дараах байдлаар тодорхойлж, тусгасан байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Хүртээмжтэй өсөлтийн бүрэлдэхүүн

		Дэлхийн банк	АХБ	ЭЗХАХБ	НҮБХХ	ОУВС	ДЭЗФ	ЕХ 202	%
Үндсэн бүрэлдэхүүн:	Үр ашгийг хуваалцах	Тэгш бус байдлын бууралт							11%
		Ядуурлын түвшин бууруулах							17%
		Байгалийн баялгийн тэнцүү хуваарилалт							3%
		Орлогын тэгш хуваарилалт							11%
		Тэнцвэртэй оролцоо, боломж							6%
	Тэгш оролцоо	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх							14%
		Хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт							9%
		Хүйсийн тэгш байдал							9%
		Ядуу бүлгийн ур чадварыг дээшлүүлэх							3%
	Тэгш боломж	Дэд бүтцийн хүртээмжтэй байдал							3%
		Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж							9%
		Нийгмийн халамжийн хүртээмж							9%
		Боловсролын хүртээмж							6%
	Сайн засаглал	Байгальд ээлтэй өсөлт							9%
		Засаг, захиргааны зохицуулалт							3%
		Нийгэм улс төрийн байдал							6%

Тайлбар: АХБ- Азийн хөгжлийн банк, ЭЗХАХБ- Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, НҮБХХ- Нэгдсэн Үндэсний байгууллагын хөгжлийн хөтөлбөр, ДЭЗФ-Дэлхийн эдийн засгийн форум, ЕХ- Европын холбоо

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Хүртээмжтэй өсөлтийг Дэлхийн банк, Олон Улсын Валютын Сан, Азийн Хөгжлийн Банк, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр (НҮБХХ), Дэлхийн эдийн засгийн

форум зэрэг байгууллагууд тодорхойлохдоо бүгд эдийн засгийн өсөлт, түүний тогтвортой бөгөөд хүртээмжтэй байдал гэж үздэг боловч түүнийг хангах үзүүлэлтүүд нь хоорондоо ялимгүй ялгаатай байна. Эдгээр хүртээмжтэй өсөлтийн тодорхойлолтуудыг бүрэлдэхүүн болон тэдгээрийн зарим үзүүлэлтүүдээр нь харьцуулан үзвэл ядуурлын бага түвшин, тэгш бус байдлын бууралт, орлогын тэгш хуваарилалт, хөдөлмөр эрхлэлтийн өсөлт, хөдөлмөрийн бүтээмжийн өсөлт, нийгмийн үйлчилгээний хүртээмжтэй байдал зэрэг үндсэн ойлголтууд түлхүү тусгагдсан байна (*Хүснэгт 1*).

Олон Улсын Валютын Сангийн хувьд (*i*) ядуурлыг бууруулах, (*ii*) тэгш бус байдлыг бууруулах, (*iii*) ажлын байр нэмэгдүүлэх, (*iv*) уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хариу арга хэмжээ авах, (*v*) хүйсийн ялгааг багасгах, (*vi*) засаглалыг сайжруулах (*Loungani, 2017; Loungani & Ostry, 2017*) зэргийг хүртээмжтэй өсөлтөд хамруулдаг байна.

Дэлхийн банк эдийн засгийн өсөлтийн хурд, эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийг хамтад нь авч үзэн богино хугацаанд орлогыг дахин хуваарилах, ажлын байр нэмэгдүүлэхээс илүүтэйгээр хөдөлмөрийн бүтээмжийг өсгөх замаар урт хугацааны эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгохыг хүртээмжтэй өсөлт гэж үзжээ.

Азийн Хөгжлийн Банкны үзэл баримтлал нь тэгш бус байдлын бууралт (*Rauniyar, Ganesh, & Kanbur, 2010*), орлогын ялгаатай байдлаас шалтгаалан орлогын бус үзүүлэлтүүд буюу эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн үйлчилгээг авч буй байдал (*Ali, Ifzal, & Son, 2007*), эдийн засгийн өсөлтөд нийгмийн бүлгээс үл харгалзан адил хувь нэмэр оруулах тэгш боломж, бололцоо (*Ali, Ifzal, & Zhuang, 2007*) зэргийг хамтад нь хүртээмжтэй өсөлт гэж үзжээ.

Хүртээмжтэй өсөлтийн эдгээр тодорхойлолтуудыг нэгтгэвэл **хүртээмжтэй өсөлт нь урт хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлт бий болсноор нийгмийн бүхий л бүлэг өсөлтийн үр өгөөжөөс тэнцүү хуваалцах, тэгш боломж бололцоогоор хангагдах, ирээдүй үеийнхнийгээ харгалзан хамгаалахын тулд хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах** зэргийг ойлгож болохоор байна.

Хүртээмжтэй өсөлтийн ойлголтод байгаль орчны тогтвортой байдлын талаар харьцангуй бага хөндсөн байдаг. Байгаль орчны доройтол, уур амьсгалын өөрчлөлт, агаарын бохирдол, нөхөн сэргээлтийн хүрээнд тухайн улс орны авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийг хүртээмжтэй өсөлттэй хамтад нь авч үзсэнээр **ногоон хүртээмжтэй өсөлт**, ногоон хөгжил зэрэг ойлголтууд бий болох болсон. Тэр дундаа, хөдөө аж ахуй, байгалийн баялгийн олборлолт, үйлдвэрлэлд суурилсан эдийн засагтай орнууд богино хугацааны өсөлтөд төвлөрөхөөс илүүтэй урт

хугацааны тогтвортой хөгжил, ирээдүй үедээ байгаль дэлхийгээс ижил үр өгөөж хүртэх боломжийг үлдээх чиглэлд анхаарлаа төвлөрүүлэхийг Sun болон бусад (2020) судлаачид зөвлөж байна.

III. Хүртээмжтэй өсөлт ба түүнд нөлөөлөгч хүчин зүйлс

1. Судлагдсан байдал

Дэлхий нийтээр сүүлийн жилүүдэд хүртээмжтэй өсөлтийг хангах чиглэлд ихээхэн ач холбогдол өгч, анхаарал хандуулж байгаа хэдий ч хүртээмжтэй өсөлтийг хэмжих, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох, тэдгээрийг дэмжих бодлогын хэрэгслүүдийг тогтоох нь бодлого боловсруулагчид, судлаачдын дунд нэлээдгүй маргааныг өрнүүлсээр байна. Энэ нь хүртээмжтэй, тогтвортой өсөлтийг хангасан улс орнуудын туршлага харилцан адилгүй байгаатай мөн холбоотой.

Манай улсын хувьд хүртээмжтэй өсөлтийн талаарх судалгааг Даваасүх (2012), Дэлгэржаргал, Арман, & Арьяасүрэн (2021) нар гүйцэтгэсэн байна. Даваасүх, (2012) судлаачийн хувьд НҮБХХ-ийн хүний хөгжлийн индексийг тооцох аргачлалд тулгуурлан хүртээмжтэй өсөлтийн индексийг өөрийн орны хувьд тооцсон. Үр дүнд 2011 оны байдлаар манай улсын нөхцөл 4.91 оноо буюу дундаж хүртээмжтэй гэсэн үр дүн гарсан байна. Харин Дэлгэржаргал, Арман, & Арьяасүрэн (2021) нарын судалгаа нь хүртээмжтэй өсөлтийг харуулах зарим үзүүлэлтүүдийн хувьд нөхцөл байдлыг тойм байдлаар харуулсан байна.

Хүртээмжтэй өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийг судалсан эмпирик ажлуудад хамаарах хувьсагч буюу өсөлт нь хэр хүртээмжтэй байгаа эсэхийг тодорхойлох асуудалтай тулгардаг. Эдийн засгийн өсөлтийн талаарх судалгаануудын дийлэнх нь өсөлт эсвэл ядуурал (*тэгш бус байдал*) гэсэн ойлголтыг тусад нь авч үздэг байсан үе саяхан. Гэвч 2000-аад оноос хойш дан ганц өсөлтийн хурд хангалттай бус, түүний хүртээмж буюу орлогын тархалтыг давхар харгалзан үзэх нь чухал болохыг онцолсоор байгаа юм. Хүртээмжтэй өсөлтийн талаарх энэхүү шинэ ойлголтыг шингээж, хамгийн анх Ali & Son (2007) нарын нийгмийн боломжийн муруйд суурилан Anand, Mishra, & Peiris (2013) нар хүртээмжтэй өсөлтийг орлогын өсөлт болон орлогын тархалтаар илэрхийлэх шинэ үзүүлэлтийг санал болгосон ба бид судалгааны ажилдаа энэхүү үзүүлэлтийг тооцож, шинжилгээндээ ашиглах болно.

Түүнчлэн, хүртээмжтэй өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийн талаарх олон улсын эмпирик шинжилгээнд хүртээмжтэй өсөлтийг нэг хүнд ногдох ДНБ эсвэл нэг хүнд ногдох ҮНО зэрэг үзүүлэлтээр төлөөлүүлэн авч үздэг. Мөн McKinley (2010) нь эдийн засгийн өсөлт, ядуурал болон эрх тэгш байдал, нийгмийн хамгааллын

хүрээнд хүртээмжтэй өсөлтийг илэрхийлэх нэгдсэн индексийг Азийн 6 орнуудын хувьд тооцсон байдаг.

Хүртээмжтэй өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлсийн талаарх хийсэн судалгааны ажлуудын голлох үр дүнгээс дурдвал инфляцын түвшний өсөлт хүртээмжтэй өсөлтөд сөргөөр нөлөөлдөг бол төсвийн дахин хуваарилалт, санхүүгийн гүнзгийрэлт, гадаад шууд хөрөнгө оруулалт болон худалдааны нээлттэй байдал, цэвэр хадгаламжийн өсөлт зэрэг нь эергээр нөлөөлдөг гэсэн үр дүнгүүд гаргажээ.

Инфляц өндөр байгаа нь баян ядуугийн ялгааг улам ихэсгэдэг бөгөөд инфляц болон ажилгүйдлийн түвшин өндөр үед ядуу бүлэг хэрэглээгээ бууруулахаас өөр сонголтгүй болдог (*Albanesi, 2007*). Үүнтэй холбогдуулан макро тогтвортой байдалд чиглэсэн мөнгөний бодлого нь инфляцыг бууруулж, үйлдвэрлэлийн хэлбэлзлийг багасгах замаар орлогын тэгш бус байдлыг бууруулж, улмаар ядуу бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах боломжтой (*Aoyagi & Ganelli, 2015*). Мөн үнийн тогтвортой байдал нь эдийн засгийн өсөлт, ажилгүйдэл, орлогын ялгаатай байдлыг бууруулах замаар хүртээмжтэй өсөлтөд эерэг нөлөө үзүүлдэг (*Cœuré, 2012*). Гэхдээ хэд, хэдэн судалгааны ажлуудын үр дүн мөнгөний бодлого нь тухайн орны нөхцөл байдлаас шалтгаалан тэгш бус байдлыг улам нэмэгдүүлж болохыг ч онцолж байна (*Coibion, Gorodnichenko, Kueng, & Silvia, 2012*).

Татвараар дамжуулан тэгш байдлыг сайжруулах бодлого нь ард иргэдийн хөдөлмөр эрхлэх, хөрөнгө оруулалт хийх сэдлийг бууруулж, эдийн засгийн идэвхжил буурахад хүргэдэг (*Okun, 1975*). Харин хүний нөөц, эрүүл мэнд, дэд бүтэц, боловсролыг сайжруулах зэрэг төсвийн дахин хуваарилалтын бодлого нь хэд, хэдэн сувгаар дамжин ядуу бүлэгт хүртээмжтэй өсөлтийг авчирдаг байна (*Turnovsky & Garcia-Penalosa, 2007; Ostry, Berg, & Tsangarides, 2014; Aoyagi & Ganelli, 2015*). Учир нь дахин хуваарилалт нь боломжтой хэсгээс олж авсан татвараар анхаарал шаардлагатай хэсэг рүү хуваарилах замаар хүртээмжтэй өсөлтийг бий болгоно гэж үздэг тул үзүүлэлтүүд хоорондоо эерэг хамааралтай байдаг. Тухайлбал, өндөр хөгжилтэй орнуудын хувьд төрийн санхүүжилтээр нийгмийн хамгааллын тогтолцоогоо бэхжүүлж, дундаж давхаргыг бүрэлдүүлж чадсан буюу төсвийн үндсэн нэг үүрэг болох дахин хуваарилалтын үүргээ сайн биелүүлэх нь хүртээмжтэй өсөлтөд сайнаар нөлөөлдөг байна. Гэвч зарим тохиолдолд улс орны хөгжлийн түвшнээс шалтгаалан төсвийн дахин хуваарилалт үр ашиггүй байх тохиолдол байдаг. Хөгжиж буй тэр дундаа Азийн орнуудын бодлого боловсруулагчид өнөөдрийг хүртэл эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд төсвийн дахин хуваарилалтын бодлогоос илүүтэй макро эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхэд төвлөрч ирсэн байдаг тул дахин хуваарилалт нь өсөлтийн хүртээмжтэй байдлыг бууруулах чиглэлд нөлөөлж болдог байна (*Aoyagi & Ganelli,*

2015). Мөн өндөр татвар тогтоох нь орлогын тэгш бус байдлыг бууруулах боловч иргэдийн татвар төлөхөөс зайлсхийх магадлал нэмэгдэх, хөдөлмөр эрхлэх сэдэл буурах нь эцсийн дүндээ эдийн засгийн өсөлтөд сөргөөр нөлөөлөх хандлага байдаг.

Хүснэгт 2. Судлагдсан байдлын тойм хүснэгт (Олон улс)

Судлаач	Хүртээмжтэй өсөлтийг илэрхийлэх үзүүлэлт	Хамрах хүрээ	Аргачлал	Үр дүн
McKinley (2010)	Үндсэн 25 үзүүлэлтүүдийн хүрээнд индекс тооцох	Азийн 6 орон	Индекс тооцох	Дэд бүтэц, нийгмийн хамгаалал, сайн засаглал нь хүртээмжтэй өсөлтийг нэмэгдүүлэхэд чухал нөлөөтэй.
Anand, Mishra, & Peiris (2013)	Нэг хүнд ногдох орлогын өсөлт болон орлогын тархалтын өсөлтийн нийлбэр	Дэлхийн 143 орон	Панел загвар	Хөгжиж буй орнуудын хувьд ХӨ-ийн хамгийн чухал нөлөөлөгч хүчин зүйлс нь макро эдийн засгийн тогтвортой байдал, хүмүүн капитал, гадаад худалдаа болон ГШХО-ын нээлттэй байдал бол санхүүгийн төрөлжилт, технологийн шинэчлэлт нь мэдэгдэхүйц нөлөөгүй байсан.
Aoyagi & Ganelli (2015)	Нэг хүнд ногдох орлогын өсөлт болон орлогын тархалтын өсөлтийн нийлбэр	Азийн орнууд	Панел загвар	Үр ашигтай хөдөлмөрийн зах зээл, макро эдийн засгийн тогтвортой байдал, төсвийн дахин хуваарилалт зэрэг нь хүртээмжтэй өсөлтийг нэмэгдүүлсэн.
Kireyev & Chen (2017)	Нэг хүнд ногдох ДНБ-ий бодит өсөлт	Микро шинжилгээ	Distributive analysis	Хүртээмжтэй өсөлт үүсээгүй. Орлогын өсөлт зөвхөн өндөр орлоготой бүлгүүдэд ажиглагдсан бөгөөд ядуу бүлгийн нөхцөл улам дордов.
Yuhuan Sun et al (2020)	Хүний хөгжлийн индекс	Хятадын 285 хот	Data Envelopment Analysis	Технологийн хурдацтай хөгжлөөс илүүтэй эрчим хүчний хэрэглээ, байгаль орчны бохирдол нь Хятад улсын ногоон хүртээмжтэй өсөлтөд нөлөөлж байна.
Muti et al 2020	Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт	Африкийн 27 орон	GMM	Засаглал нь хүртээмжтэй өсөлтөд эерэг хамааралтай байна.
Alekhina & Ganelli (2020)	Нэг хүнд ногдох орлогын өсөлт болон тархалтын өсөлтийн индекс	Ази номхон далайн бүс нутгийн 11 орон	Панел загвар	Төсвийн дахин хуваарилалт, хөдөлмөрийн зах зээлд чиглэсэн бүтцийн бодлого нь хүртээмжтэй өсөлтийг мэдэгдэхүйц хурдасгахад тусална.

Эх сурвалж: Судлаачдын нэгтгэл

Хүртээмжтэй өсөлтийн талаарх эмпирик ажлуудад санхүүгийн зах зээлийн хүртээмж, гүнзгийрэлт зэрэг үзүүлэлтийг ашигласан ажлууд цөөнгүй байдаг. Санхүүгийн гүнзгийрэлтийг илэрхийлж болох хувийн хэвшилд олгосон дотоодын зээлийн ДНБ-д эзлэх хувь болон хүртээмжийн өсөлт эерэг хамаарал байдгийг Ross (2005) болон Nizam, Karim, Rahman, & Sarmidi (2020) нарын судалгаануудын үр

дүн харуулдаг. Гэвч санхүүгийн гүнзгийрэлтийг хүртээмжтэй өсөлт гэхээс илүүтэй эдийн засгийн өсөлттэй холбож тайлбарласан байна. Харин Alekhina & Ganelli (2020) болон Anand, Mishra, & Peiris (2013) нарын ажлуудад хоорондын хамаарал сөрөг боловч статистикийн хувьд ач холбогдолгүй гарсан байна.

Хүртээмжтэй өсөлтөд нөлөөлөх үзүүлэлтүүдийг судалсан ажлууд мөнгөний, төсвийн бодлогын, макро бүтцийн бодлогын хүрээнд нийтлэг хувьсагчдыг сонгон авч үнэлсэн ч ялгаатай үр дүнгүүдэд хүрсэн байна. Зарим судалгааны ажлын голлох үр дүнг Хүснэгт 2-т тоймлон харууллаа.

Технологийн дэвшил, даяаршил, инновац зэрэг нь хөгжиж буй Азийн орнуудад эдийн засгийн өсөлтийг бий болгосон хэдий ч тэгш бус байдлыг нэмэгдүүлсэн байна (Zhuang, Kanbur, & Rhee, 2014). Иймд эдгээр орнууд тогтвортой, хүртээмжтэй өсөлтийг бий болгохын тулд хүн амын дийлэнх хэсгийг хамарсан бүтээмжтэй ажлын байрыг бий болгох, хөдөлмөрийн зах зээлийг дэмжих бодлого хэрэгтэйг онцолжээ. Энэхүү үр дүнтэй Balakrishman, Chad, & Murtaza (2013) нар нийлж байгаа бөгөөд ядуурлын түвшин буурч байгаа хэдий ч Азийн орнуудын эдийн засгийн өсөлт хүртээмж бага байгааг харуулсан байна. Үүний эсрэг Chandra, Kinda, Kochhar, Piao, & Schauer (2016) нар эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөрийн зах зээлийн шинэчлэл, илүү хүртээмжтэй санхүүгийн зах зээлд чиглэсэн төсвийн бодлого нь тэгш бус байдлыг бууруулахад чухал нөлөө үзүүлж болохыг олж тогтоосон.

2. Хүртээмжтэй өсөлтийг хэмжих нь

Хүртээмжтэй өсөлтийг хэрэглэгчийн сонголтын онолд суурилан нийгмийн шилжилтийн функц (*social mobility function*) ашиглан хамгийн анх Anand, Mishra, & Peiris (2013) судлаачид тооцсон байдаг. Хэрэглэгчийн сонголтын тухай онолд тухайн хэрэглэгчийн хэрэглээний хослолын хувьд ижил таашаагддаг бүтээгдэхүүнүүдийн сагсны олонлогийг Ялгаагүйн муруй харуулдаг. Үүний адилаар хүртээмжтэй өсөлт нь орлогын болон орлуулалтын нөлөөгөөр дамжин

1. **Орлогын өсөлт** буюу нийт хүн амд оногдож буй дундаж боломж/өсөлт (*income growth*);
2. **Орлогын тархалт** буюу нийт хүн амын бүлэг хооронд боломж/өсөлт нь хэрхэн хуваарилагдаж буй байдал (*income distributions*) гэсэн 2 бүрэлдэхүүний хүрээнд задрах боломжтой гэж үзсэн байна.

Өөрөөр хэлбэл Anand, Mishra, & Peiris (2013) нарын судалгаанд хүртээмжтэй өсөлтийг эдийн засгийн өсөлт (*income growth*) болон түүний хуваарилалт нь нийт хүн амын ялгаатай орлогын түвшинд жигд өсөлт (*equity growth*) авчирч чадсан

эсэхээр тодорхойлогдсон байна.

Ali & Son (2007) нарын дагуу орлогыг боломж гэж үзвэл n хүн амын орлогын хуваарилалтыг орлогын түвшний өсөх дарааллаар индексжүүлэн, x_i орлоготой i -р хүний y_i боломжийн функцийг дараах байдлаар тодорхойлж болно.

$$0 = 0 (y_1, y_2, \dots, y_n) \quad (1)$$

Тухайн хүний орлого (боломж) нэмэгдэхэд боломжийн функц мөн нэмэгдэж байна гэсэн үг юм. Орлого тэгш хуваарилагдах боломж ихсэх (ядуу бүлгийн амьжиргааны түвшний өсөлт) тусам илүү хүртээмжтэй байна.

Үүн дээр тулгуурлан Нийгмийн шилжилтийн муруй (social mobility curve) Sc-г дараах байдлаар илэрхийлж болно.

$$Sc \approx (y_1, \frac{y_1 + y_2}{2}, \frac{y_1 + y_2 + y_3}{3}, \dots, \frac{\sum_j^i y_j}{i}, \dots, \frac{\sum_j^n y_j}{n}) \quad (2)$$

Энд i нь орлогын түвшний перцентиль утгыг илэрхийлнэ. Нийгмийн шилжилтийн муруй нь хамгийн бага орлоготой бүлгээс илүү өндөр орлогын бүлэгт орох боломжийг илэрхийлдэг. Орлогын тархалтын хэмжээг тодорхойлохын тулд Anand et al (2013) нийгмийн шилжилтийн муруйн доорх талбайг олох замаар шилжилтийн индексийг тооцсон:

$$\bar{y}^* = \int_0^{100} \bar{y}_i d \quad (3)$$

Хэрвээ \bar{y}^* нь \bar{y} -ын утгатай тэнцүү байвал хүн амын бүх бүлгийн дундаж орлого тэнцүү байна гэсэн үг юм. Харин \bar{y}^* нь \bar{y} -ээс бага байвал орлогын хуваарилалт тэгш бус байгааг илэрхийлнэ. Үүнээс үүдэн орлогын тархалтын индекс (*Income Equity Index*)-ийг дараах байдлаар тооцоолж болно.

$$\omega = \frac{\bar{y}^*}{\bar{y}} \quad (4)$$

Энд ω нь 0-ээс 1-ийн хооронд утга авах ба 1 нь орлогын бүрэн тэгш хуваарилалтыг, 0 нь тэгш бус байгааг харуулна. Тэгшитгэл (4)-өөс орлогын тархалтын өсөлтийн тэгшитгэлийг гаргавал дараах байдлаар бичигдэнэ.

$$d\bar{y}^* = \bar{y}d\omega + \omega d\bar{y} \quad (5)$$

Энд $d\bar{y}^*$ нь хүртээмжтэй өсөлтийн өөрчлөлтийг илэрхийлэх бөгөөд хэрэв $d\bar{y}^* > 0$ бол хүртээмжтэй өсөлт байна гэж дүгнэж болно. Ийнхүү хүртээмжтэй өсөлтийг нэгт орлогын өсөлт, хоёрт орлогын тархалтын өсөлт гэсэн бүрэлдэхүүнд задлах боломжтой байна.


$$\frac{d\bar{y}^*}{\bar{y}^*} = \frac{d\bar{y}}{\bar{y}} + \frac{d\omega}{\omega} \quad (6)$$

Тэгшитгэл (6)-д харуулснаар нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт болон бүлэг хоорондын орлогын тархалтын индексийн өсөлтийг хамтатган хүртээмжтэй өсөлтийн нэгдсэн үзүүлэлт гаргаж болно. Мөн цаг хугацааны хувьд, улс орнуудын хооронд харьцуулах боломж олгодгоороо давуу талтай.

3. Хүртээмжтэй өсөлтийн нөхцөл байдал

Өмнөх бүлэгт McKinsey (2021) хүртээмжтэй өсөлтийг эдийн засгийн өсөлт болон түүний хуваарилалт нь нийт хүн амын амын бүх орлогын түвшинд жигд өсөлт ажиглагдсан үед үүсдэг хэмээн тайлбарласан. Энэхүү санаанд тулгуурлан дэлхийн нийт 90 гаруй орны хувьд сүүлийн 4-7 жилийн хугацаан дахь ДНБ-ээр илэрхийлэгдсэн эдийн засгийн өсөлт болон орлогын хүртээмжтэй байдлыг тооцон Зураг 2-т дүрслэв.

Зураг 2. Эдийн засгийн өсөлт ба хүртээмжтэй байдал



Тайлбар: Энд эдийн засгийн өсөлт нь ДНБ-ий өсөлтийг, орлогын хүртээмжтэй байдал нь хүн амын хамгийн бага орлоготой 40%-ийн дундаж орлогын өсөлтийг илэрхийлнэ. Хугацааны хувьд тухайн орны боломжит мэдээллээс хамааран хамгийн боломжит сүүлийн 4-7 жилийн хугацаан дахь дундаж жилийн өсөлтөөр илэрхийлье.

Эх сурвалж: Судлаачийн зураглал

Эдийн засгийн өсөлтийн үр өгөөж улс хооронд ялгаатай байхаас гадна улс дотроо нийгмийн бүлэг, хүн амын хооронд тэгш бус байгааг харж болохоор байна. Ихэнх орнууд зургийн баруун дээд мужид оршиж байгаа буюу эдийн засгийн өсөлт нь хамгийн бага орлоготой 40 хувийн дундаж орлогыг нэмэгдүүлсэн байна. Румын, Болгар зэрэг зарим орнуудын тухайд эдийн засгийн өсөлт тийм ч өндөр биш

боловч хамгийн бага орлоготой иргэдийн орлого 10-14 хувиар өссөн нь тогтвортой хөгжлийг хангаж чадаж байгааг харуулж байгаа юм. Энэ нь хүртээмжтэй өсөлтөд эдийн засгийн өсөлт чухал боловч өсөлт нь заавал өндөр байх шаардлагагүйн зэрэгцээ өсөлтийг нийгмийн бүлгүүдэд тэгш хуваарилах, хүмүүсийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх нь чухал гэдгийн тод жишээ билээ. Мөн өндөр, тогтвортой эдийн засгийн өсөлт нь чухал боловч хүртээмжтэй өсөлтийн хүрэлцээтэй нөхцөл биш болохыг зургийн баруун дээд мужид байгаа Лаос улсын жишээнээс харж болохоор байна. Харин Уганда, Гани, Танзани зэрэг Африкийн орнуудын хувьд (зургийн доод хэсэгт байгаа) эдийн засаг дунджаар 4-7 хувиар тэлсэн ч бага орлоготой иргэдийн орлого улам доройтсон дүр зураг ажиглагдаж байна.

Манай орны хувьд эдийн засаг 2011-2018 онд жилд дунджаар 6.9 хувиар өргөжсөн ч хамгийн бага орлоготой **40% иргэдийн дундаж орлого ердөө 1 хувиар нэмэгдсэн** байгаа нь хүртээмжтэй өсөлт сул байгаагийн илрэл билээ. Судлаач Дэлгэржаргал, Арман, & Арьяасүрэн (2021) нар манай орны хүртээмжтэй өсөлт бусад орнуудтай харьцуулахад сул байгаа бөгөөд үүнд орлогын тэгш бус байдал, ядуурлын түвшин өндөр, эрүүл мэндийн хүртээмж муу, боловсролын чанарын ялгаа өндөр байгаа нь нөлөөлсөн гэж дүгнэжээ (*Шигтгээ 1*).

Билгүүнзул (2019) судалгаанд Монгол улсын хувьд жини коэффициентоор илэрхийлэгдэх орлогын тэгш бус байдал бусад орнуудтай харьцуулахад харьцангуй бага бүлэгт тооцогддог боловч энэ нь орлогын гэхээс илүүтэй хөрөнгийн тэгш бус байдал оршиж болзошгүйг онцолсон. Учир нь орлогын тэгш бус байдлын **70 орчим хувийг өрхийн хөрөнгө** тодорхойлж байсан бол боловсролын түвшин ердөө 5 орчим хувийг эзэлж байсан. Энэ нь манай улс байгалийн баялгийн хараат байдлаас хамааран боловсролын салбарт оруулах хөрөнгө оруулалт бага улмаар боловсролын хүртээмжгүй байдал, боловсролын салбарын чанар стандарт, түүний өгөөж болон үнэлэмж сул байгаад нөлөөлж байх талтай байна.

Шигтгээ 1: Монгол Улсын хүртээмжтэй өсөлт

Монгол Улсын хувьд хүртээмжтэй байдал сул байгаа ба цар тахлын нөхцөл байдлаас үүдэн цаашид муудах хүлээлттэй байна. Зарим гол үзүүлэлтүүдийг авч үзвэл дараах байдалтай байна.

Орлогын тэгш бус байдал өндөр: Монгол Улсын хувьд тэгш бус байдлын үндсэн үзүүлэлт болох “жини коэффициент” 2021 оны байдлаар 0.327 байгаа нь дэлхийн улс орнуудтай харьцуулахад орлогын тэгш бус байдал харьцангуй бага боловч нийт хүн амын зөвхөн 20 хувь нь нийт орлогын 40 гаруй хувьтай тэнцэх хэмжээний орлогыг эзэлж байгаа нь тэгш бус байдал өндөр байгааг илтгэж байна.

Ядуурлын түвшин өндөр: Ядуурлын түвшин 2010 онд 38.8 хувь буюу ойролцоогоор 10 хүн тутмын 4 нь ядуу байсан бол 2018 оны байдлаар ядуурлын түвшин 28.4 хувь буюу ойролцоогоор 4 хүн тутмын 1 нь ядуу болж ядуурлын түвшин буурсан байна. Гэсэн хэдий ч хүн амын 15 орчим хувь нь ядуурлын шугамын ойролцоо байгаа буюу ядууралд өртөх эрсдэлтэй байна. Эдгээр иргэд нь эдийн засаг, эрүүл мэнд, уур амьсгал зэрэгт сөрөг өөрчлөлт ороход ядууралд өртөх хамгийн өндөр эрсдэлтэй юм.

Эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж бүс хооронд муу: Хүн амын эрүүл мэндийн салбарын нөөц хангалттай хэмжээнд байгаа ч газар зүйн байршлын хувьд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж тэгш бус байна. Тухайлбал, 1000 км² талбайд оногдох эмч, сувилагчийн тоо хотод 1228, 1185 байхад аймгийн төвүүдэд 193, 260, харин хөдөөд 2.7, 4 байна.

Боловсролын чанарын ялгаа өндөр: Тодорхой хэмжих үзүүлэлт байхгүй, хүйсийн ялгаварлал харьцангуй багатай боловч чанартай боловсрол эзэмших боломжийн ялгаатай байдал, төр болон хувийн хэвшил, бүс хоорондын (хот болон хөдөө орон нутаг) тэгш бус байдал өндөр байна.

Санхүүгийн хүртээмж сайн боловч санхүүгийн гүнзгийрэлтийг сайжруулах шаардлагатай: Манай орны хувьд санхүүгийн хүртээмж дунд орлоготой орнуудаас сайн байна. Гэвч санхүүгийн секторт банкны систем давамгайлж, жижиг дунд үйлдвэрлэлд санхүүжилтийн хүртээмж сул, урт хугацаатай санхүүжилтийн хэрэгцээг хангаж чадахгүй байна.

Тогтвортой хөгжлийн асуудал тулгамдсан хэвээр байна: Монгол Улсын эрс тэс уур амьсгал, дэлхийн дулаарал, хотжилт, орчны бохирдол зэргээс үүдэлтэйгээр хүрээлэн буй орчин доройтож байна. Эдийн засгийн эмзэг бүтэц, тодруулбал уул уурхай, мал аж ахуйн салбар эдийн засгийн үйл ажиллагаанд голлох үүрэг гүйцэтгэсээр байгаа нь байгаль орчны болоод эдийн засгийн тогтвортой байдалд сөрөг нөлөөг үзүүлж байна. Тухайлбал, ядуурал нэмэгдэх нь хүмүүсийн биет болон хүмүүн капиталын хуримтлал бий болгох, шинэ бизнес, шинэ технологи нэвтрүүлэх зэргийг хойш татаж, эдийн засгийн боломжит өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж байдаг.


Бид энэхүү судалгаанд Азийн 22 орны хувьд Тэгшитгэл (6)-д суурилан хүртээмжтэй өсөлтийг тооцоолж, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьсон. Ингэхийн тулд эхлээд зарим орнуудын хүн амын бүлэг хоорондын дундаж орлогын Ялгаагүйн муруй буюу тэгшитгэл (2)-т үзүүлсэн нийгмийн шилжилтийн муруйг дүрслэн харууллаа (Зураг 3).

Энэхүү муруй нь хүн амын ялгаатай бүлгүүдийн дундаж орлогыг хугацааны хувьд хэрхэн өөрчлөгдсөнийг харуулдаг. Иймд Зураг 3-т хүн амын орлогын түвшнээр тэнцүү хуваасан 10 бүлэг бүрд оногдох нэг сарын дундаж орлогыг дүрсэллээ.

Сонгож авсан 4 улсын хувьд эдийн засгийн өсөлт нь сүүлийн 20 орчим жилд муруйг дээш шилжүүлсэн буюу нийгмийн бүх бүлгийн дундаж орлого нэмэгдсэн боловч муруйн түвшний шилжилт, налалт нь өөр хоорондоо ялгаатай байгаа юм. Тухайлбал, БНХАУ-ын хувьд эдийн засгийн өсөлтийн үр өгөөж хурдацтай байсан нь хүн бүрд үр ашгаа өгсөн боловч өндөр орлоготой бүлгүүдийн орлогыг илүү нэмэгдүүлсэн буюу тэгш бус байдал нэмэгдсэнийг харж болохоор байна.

Манай улсын хувьд 1995 онтой харьцуулахад 2018 онд хамгийн өндөр орлоготой 10 хувийн бүлгийн орлого хамгийн бага орлоготой 10 хувийн бүлгийн орлогоос илүү их өссөн нь харагдаж байна. Энэ нь БНХАУ-тай харьцуулахад харьцангуй бага буюу орлогын тэгш бус байдал бага байгаа боловч эдийн өсөлтийн хурд тааруу байна.

Зураг 3. Азийн зарим орнуудын ялгаагүйн муруй (Нийгмийн шилжилтийн муруйн өөрчлөлт)



Эх сурвалж: Судлаачийн зураглал


Харин эдийн засгийн өндөр өсөлтийн үр өгөөжөөс тэнцүү хүртэх боломж нэмэгдсэн (Тайланд) эсвэл эдийн засгийн өсөлт төдийлөн өндөр биш байсан ч

орлогын тэгш байдал өссөн (*Киргиз*) туршлагыг Ялгаагүйн муруй болон Зураг 4-т дүрсэлсэн хүртээмжтэй байдлын матрицаас харж болно.

Судалгааны дараагийн хэсэгт хүртээмжтэй өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлохоос өмнө хүртээмжтэй өсөлтийг нэг хүнд ногдох ДНБ болон орлогын тархалтын өсөлтөөр тодорхойлж Азийн 22 орны хувьд тооцсоныг Зураг 4-т дүрсэллээ. Орлогын тархалтын өсөлтийг тооцохдоо тухайн орны хүн амын ялгаатай 10 бүлгийн дундаж орлогод суурилсан шилжилтийн муруйн доод талбайн хэмжээг олох замаар сүүлийн 20 орчим жилийн хугацаан дахь дундаж жилийн өсөлтийг тодорхойлсон.

Судалгаанд авч үзсэн Азийн орнууд эдийн засгийн өсөлттэй боловч орлогын тархалтын өсөлт нэмэгдсэн эсвэл буурсан 2 мужид багтаж байна. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн өсөлт хурдассанаар хүн амын орлогын тэгш бус байдал нэмэгдэх үү эсвэл эсрэг тохиолдол биелэх үү гэдэг нь улс орнуудын хувьд “trade-off” сонголт байх шаардлагагүй байна. Тухайлбал, сонгож авсан Азийн 22 орноос Тайланд, Армен, Казакстан зэрэг 7 орон тэгш бус байдлыг нэмэгдүүлэлгүйгээр эдийн засгийн өсөлтөд хүрсэн бөгөөд энэ нь хүртээмжтэй өсөлтийн илрэл юм.

Зураг 4. Азийн зарим орнуудын хүртээмжтэй байдлын матриц




Тайлбар: Орлогын өсөлт болон орлогын тархалтын өсөлт нь 1990-ээд оноос боломжит хамгийн сүүлийн оны хугацаан дахь дундаж жилийн өсөлтөөр илэрхийлэгдэнэ. Дүрсийн хэмжээ нь нэг хүнд ногдох ДНБ-ий суурь түвшинг харуулна.

Эх сурвалж: Судлаачийн зураглал

Манай орны хувьд 1998-2018 онуудад эдийн засгийн жилийн дундаж өсөлт 5.2 хувь байгаа нь сонгож авсан Азийн ихэнх орнуудтай харьцуулахад өндөр байгаа боловч орлогын тархалтын дундаж жилийн өсөлт -0.1 хувь байна. Ийнхүү орлогын хүртээмжтэй байдал сөрөг байгаа нь сүүлийн 20 жилийн манай орны **хүртээмжтэй өсөлтийг илэрхийлэх үзүүлэлтийг 5.1 хувь байсан гэж хэлж болохоор байна.**

Зураг 5. Монгол улсын хүртээмжтэй байдлын матрицын шилжилт



Тайлбар: Орлогын өсөлт болон орлогын тархалтын өсөлт нь 4-6 жилийн хугацаан дахь (1996-2002, 2002-2008, 2008-2012, 2012-2018) дундаж жилийн өсөлтөөр илэрхийлэгдэнэ. Хүртээмжтэй өсөлт нь 2 өсөлтийн нийлбэрээр буюу харгалзан 2.4%, 6.8%, 7.4%, 4.4% хувь байна.

Эх сурвалж: Судлаачийн зураглал

Монгол улсын эдийн засгийн хүртээмжтэй байдлын матрицын шилжилтийг тоон мэдээний хүрэлцээтэй байдлаас хамааран 4-6 жилийн хугацааны интервалтай харууллаа (Зураг 5). Орлогын тархалтын жилийн дундаж өсөлт 1996-2002 онуудад 0.1 хувь, эдийн засгийн өсөлт 2.3 хувь байсан нь хүртээмжтэй өсөлтийг **2.4 хувь** байхад нөлөөлсөн. Харин 2002-2008 онуудад эдийн засгийн өсөлт өндөр (**7.4 хувь**) байсан ч орлогын тархалтын өсөлт буурсан буюу хүртээмжтэй өсөлт **6.8 хувьтай** байсан байна. Улмаар 2008-2012 он болон 2012-2018 онуудад хүртээмжтэй өсөлт дунджаар харгалзан 7.4 хувь болон 4.4 хувь байна.

4. Аргачлал ба тоон өгөгдөл

ОУВС-ийн судлаач Anand, Mishra, & Peiris (2013) нарын судалгааны ажилд Alekhina & Ganelli (2020) нарын загварыг өргөтгөн хүртээмжтэй өсөлтөд нөлөөлөх хүчин зүйлсийг судалсан бөгөөд бид энэхүү судалгааны ажилдаа тус загварт ашигласан хүртээмжтэй өсөлтийг илэрхийлэх үзүүлэлтийг үндсэн суурь болгон ашиглаж, судлахыг зорьсон. Судалгааны ажилд хүртээмжтэй өсөлтийг илэрхийлж болох мөнгөний, төсвийн, макро бүтцийн бодлогын хувьсагчдыг Азийн 22 орны хувьд

Дэлхийн банк, ОУВС болон Дэлхийн орлогын тэгш бус байдлын мэдээллийн сангийн тоон мэдээлэлд үндэслэн сонгож 1992-оос 2020 оны хувьд Панел загварыг үнэлсэн. Ингэхдээ олон улсад хийгдсэн судалгааны ажлуудын нийтлэг жишиг болон тоон мэдээллийн хүрэлцээтэй байдлыг харгалзан тайлбарлагч хувьсагчдыг сонгосон.

Загварын ерөнхий хэлбэр нь дараах байдлаар илэрхийлэгдэнэ.

$$\Delta \bar{y}_{i,t}^* = \beta_0 + \beta_1 \bar{y}_{i,t} + \beta_2 X_{i,t} + e_{i,t} \quad (7)$$

Энд $\Delta \bar{y}_{i,t}^*$ нь t үе дэх i дугаар орны хүртээмжтэй өсөлтийг илэрхийлэх үзүүлэлт, β_0 нь тогтмол хувьсагч, $e_{i,t}$ нь улс орнуудын онцлог болон цаг хугацаанаас хамааран үүсэх алдааны хувьсагч болно. Харин $\bar{y}_{i,t}$ нь 2015 оноор зэрэгцүүлсэн нэг хүнд ногдох ДНБ-ий суурь өсөлт, тайлбарлагч вектор болох $X_{i,t}$ нь мөнгөний болон төсвийн бодлого, бүтцийн хувьсагчдыг илэрхийлнэ. Тухайлбал, инфляцын түвшин, орлогын дахин хуваарилалт, санхүүгийн гүнзгийрэлтийн түвшинг илэрхийлэх хувийн хэвшилд олгосон дотоодын зээлийн ДНБ-д эзлэх хувь, гадаадын шууд хөрөнгө оруулалтын ДНБ-д эзлэх хувь, худалдааны нээлттэй байдал буюу гадаад худалдааны ДНБ-д эзлэх хувь болон нийт цэвэр хадгаламжийн ДНБ-д эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүдийг¹ үнэлгээнд ашигласан. Загварт эдгээр хувьсагчдаас гадна тухайн орны засаглал, институтийн чанар, боловсрол, эрүүл мэндийн салбарт оруулж буй хөрөнгө оруулалт зэрэг хувьсагчдыг оруулсан боловч статистикийн хувьд төдийлөн ач холбогдолгүй гарсан тул үнэлгээнд хасаж тооцсон болно.

5. Панел үнэлгээний голлох үр дүн

Азийн орнуудын хүртээмжтэй өсөлтөд мөнгөний, төсвийн, макро бүтцийн хувьсагчид нөлөөлж буй эсэхийг судлахдаа Панел өгөгдөл ашиглан Тогтмол болон Санамсаргүй нөлөөний аргыг ашиглан үнэлгээг гүйцэтгэж үр дүнг Хүснэгт 3-т харьцуулан харуулсан болно.

Үнэлгээ (1)-д хүртээмжтэй өсөлт болон өмнөх жилийн ДНБ-ий өсөлт хоорондын хамаарлыг нэгтгэсэн Хамгийн Бага Квадратын Арга (ХБКА)-аар үнэлсэн. Харин үнэлгээ (2) болон (3)-т тогтмол ба санамсаргүй нөлөөний (*Fixed effects and Random effects*) загварын үр дүнг харуулсан. Энгийн ХБКА (1) болон санамсаргүй нөлөөний загвар (3) хооронд сонголт хийхэд Breusch-Pagan LM тест тусалдаг бөгөөд үр дүнгээс харахад магадлалын утга нь 0.000-тай тэнцүү байгаа нь улс хоорондын вариаци нь тэгтэй тэнцүү гэсэн H_0 таамаглалыг няцааж байна.

Харин санамсаргүй болон тогтмол нөлөөний үнэлгээний 2 аргачлалын аль нь илүү тохиромжтойг Хаусмэны шалгуураар тодорхойлсон. Энэхүү тест нь

¹ Хувьсагчдын дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт 3-аас харна уу.

үнэлгээний алдаанууд нь тайлбарлагч хувьсагчуудтай хамааралгүй эсэхийг шалгадаг бөгөөд үр дүнгээр магадлалын утга нь 0.99 буюу $\chi^2(9)$ тархалтын критик утгаас давснаар H_0 таамаглал болох санамсаргүй нөлөөний арга гажуудалгүй бөгөөд илүү үр дүнтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Иймд цаашид үнэлгээний үр дүнг санамсаргүй нөлөөний аргад суурилан тайлбарлалаа.

Хүснэгт 3. Хүртээмжтэй өсөлтийн Панел үнэлгээний үр дүн

Тайлбарлагч хувьсагчид	Тайлбарлагдагч хувьсагч: Хүртээмжтэй өсөлт		
	(1) Pooled OLS	(2) Fixed effects	(3) Random effects
ДНБ-ий жилийн өсөлт (-1)	0.328 *** [0.046]	0.077 [0.050]	0.121 ** [0.049]
Инфляц		-0.050 * [0.028]	-0.035 * [0.027]
Орлогын дахин хуваарилалт		-0.142 [0.635]	-0.174 ** [0.08]
ГШХО-ын ДНБ-д эзлэх хувь		0.166 *** [0.036]	0.165 *** [0.035]
Хувийн хэвшилд олгосон дотоодын зээлийн ДНБ-д эзлэх хувь		-0.023 [0.013]	-0.017 *** [0.006]
Нийт цэвэр хадгаламжийн ҮНО-д эзлэх хувь		0.067 ** [0.035]	0.071 *** [0.027]
Гадаад худалдааны ДНБ-д эзлэх хувь		0.034 *** [0.011]	0.014 ** [0.006]
Тогтмол		1.20 [2.60]	3.38 *** [0.847]
Hausmen test (p-value)		0.99	
LM test (Breusch-Pagan)			0.000
Observations		261	261
R ²	0.14	0.18	0.17

Тайлбар: Энд ***, **, * нь харгалзан 1%, 5%, 10%-ийн ач холбогдлын түвшинг, [] хаалтад стандарт хазайлтыг илэрхийлнэ.

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол

Инфляцын түвшин: Макро эдийн засгийн болон үнийн тогтвортой байдал нь хүртээмжтэй өсөлтийн хэмжигдэхүүнүүдэд чухал нөлөө үзүүлдэг. Үнэлгээнд мөнгөний бодлогыг илэрхийлэх үзүүлэлт болгож инфляцын түвшний нөлөөг авч үзвэл хүртээмжтэй өсөлтийг бууруулах чиглэлд нөлөөлж байгаа нь үнийн тогтвортой байдал нь эдийн засгийн өсөлт, ажилгүйдэл, орлогын ялгааг бууруулах замаар хүртээмжтэй өсөлтөд эерэг нөлөө үзүүлдэг гэсэн анхны таамаглалтай нийцтэй байна. Нөлөөллийн коэффициентын (-0.03) хувь олон улсад ижил төстэй хийгдсэн судалгаануудын үр дүнтэй² ижил байна. Өөрөөр хэлбэл инфляцын

² (Anand, Mishra, & Peiris, 2013) нарын дэлхийн нийт 143 орны хувьд, (Alekhina & Ganelli, 2020) нарын Ази номхон далайн бүс нутгийн 6 орны хувьд тооцсон үнэлгээнд инфляцын хүртээмжтэй

түвшин нэг хувиар өсөх нь хүртээмжтэй өсөлтийг 0.03 хувиар бууруулдаг гэсэн үр дүн гарлаа.

Орлогын дахин хуваарилалт: Үнэлгээний үр дүнгээр Азийн орнуудын хувьд орлогын дахин хуваарилалт (*татварын өмнөх болон дараах орлогын жини коэффициент*) нь хүртээмжтэй өсөлтөд сөргөөр буюу 1 нэгжээр өсөх нь хүртээмжтэй өсөлтийг 0.17 хувиар ³ бууруулах нөлөөтэй гарсан. Энэ нь Gründler & Scheuermeyer (2018) нарын 100 гаруй орны хувьд тооцсон дахин хуваарилалтын нэг нэгжийн өсөлт нь эдийн засгийн өсөлтөд 0.27 хувийн сөрөг нөлөөтэй гэсэн үр дүнтэй ойролцоо түвшинд гарлаа. Хөгжиж буй тэр дундаа Азийн орнуудын хувьд дахин хуваарилалт нь өсөлтийн хүртээмжтэй байдлыг бууруулах чиглэлд нөлөөлж болдог байна (*Aoyagi & Ganelli, 2015*). Иймд бодлого боловсруулагчид өөрийн орны онцлогт тохирсон төсөв, татварын бодлого хэрэгжүүлэх, зарцуулалтын оновчтой байдал, үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байж болзошгүй.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт ба худалдааны нээлттэй байдал: Энэхүү 2 макро бүтцийн үзүүлэлтүүд нь хүртээмжтэй өсөлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг болох нь статистикийн хувьд ач холбогдолтой гарсан бөгөөд анхны таамаглалтай нийцтэй байна. ГШХО-ын ДНБ-д эзлэх хэмжээ 10 хувиар нэмэгдэх нь хүртээмжтэй өсөлтийг 1.6 хувиар нэмэгдүүлэх нөлөө гарсан. Харин гадаад худалдааны нээлттэй байдлын үзүүлэх нөлөө харьцангуй бага буюу 10 хувиар нэмэгдэх нь хүртээмжтэй өсөлтөд 0.1 хувийн эерэг нөлөө авчрахаар байна.

Санхүүгийн гүнзгийрэлт: Санхүүгийн гүнзгийрэлтийг илэрхийлж болох хувийн хэвшилд олгосон дотоодын зээлийн ДНБ-д эзлэх хувь болон хүртээмжийн өсөлт хооронд сөрөг хамаарал ажиглагдсан бөгөөд статистикийн хувьд ач холбогдолтой гарсан нь анхны таамаглалаас зөрүүтэй байна. Нөлөөллийн коэффициентын хувь (-0.017) буюу хувийн хэвшилд олгосон дотоодын зээлийн ДНБ-д эзлэх хувь 10 хувиар өсөхөд хүртээмжтэй өсөлтийг 0.1 хувиар бууруулна гэсэн үр дүн гарлаа. Эндээс хувийн хэвшилд олгосон дотоодын зээл хэр хүртээмжтэй вэ гэсэн асуулт урган гарч ирж байна.

Цэвэр хадгаламж: Цэвэр хадгаламжийн хэмжээ их байх нь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, тэгш байдлыг дээшлүүлэх замаар эдийн засгийн өсөлтийг дэмждэг. Үнэлгээний үр дүнгээр цэвэр хадгаламжийн ҮНО-д эзлэх хувь 10 хувиар нэмэгдэх нь хүртээмжтэй өсөлтийг 0.7 хувиар дэмжихээр байгаа бөгөөд бусад судалгаануудын үр дүнтэй нийцтэй байна.

өсөлтөд үзүүлэх нөлөөг харуулсан коэффициент нь харгалзан (-0.02), (-0.03) байна.

³ *Орлогын дахин хуваарилалтын коэффициентыг болгоомжтой тайлбарлах хэрэгтэй. Учир нь тус үзүүлэлтийн тооцоолол нь улс орны ашигласан мэдээллээс хамааран ялгаатай тооцоолсон байх боломжтой байна*

IV. Дүгнэлт

Аливаа улсын хөгжил, ард иргэдийн амьдрах нөхцөл, амьдралын чанарыг илэрхийлэхэд хүртээмжтэй өсөлтийг чухалчлах болсон. Хүртээмжтэй өсөлт нь энгийнээр авч тодорхойлбол эдийн засгийн өсөлт болон түүний хуваарилалт нь нийт хүн амын орлогын бүх түвшинд жигд байх өсөлтийг хэлнэ. Гэвч энэ талаар олон улсын байгууллагууд нэгдсэн нэг тодорхойлолтод хараахан хүрээгүй байна. Тухайлбал, олон улсын томоохон байгууллагууд хүртээмжтэй өсөлтөд эдийн засгийн өсөлтөөс гадна ядуурлын бага түвшин, тэгш бус байдлын бууралт, орлогын тэгш хуваарилалт, хөдөлмөр эрхлэлтийн өсөлт, нийгмийн үйлчилгээний хүртээмжтэй байдал зэргээр тодорхойлж байна.

Азийн 22 орон, түүн дотроо Монгол Улсын хувьд хүртээмжтэй өсөлтийг тооцоолж, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг илрүүлэх зорилгоор энэхүү судалгааны ажлыг боловсруулав. Судалгааны хүрээнд Нийгмийн шилжилтийн муруйнд үндэслэн хүртээмжтэй өсөлтийг орлогын өсөлт болон орлогын тархалтын өсөлтийн нийлбэрээр тодорхойлсон, 2) хүртээмжтэй өсөлтөд мөнгөний, төсвийн, макро бүтцийн хувьсагчид нөлөөлж буй эсэхийг панел өгөгдөл ашиглан үнэлсэн болно.

Хүртээмжтэй өсөлтөд эдийн засгийн өсөлт чухал боловч эдийн засаг өсөхийн зэрэгцээ өсөлтийг нийгмийн бүлгүүдэд тэгш хуваарилах, хүмүүсийн сайн сайхан байдлыг нэмэгдүүлэх нь чухал байна. Мөн өндөр, тогтвортой эдийн засгийн өсөлт нь чухал боловч хүртээмжтэй өсөлтийн хүрэлцээтэй нөхцөл биш болохыг Азийн орнуудын жишээ харуулсан. Манай орны эдийн засаг 2011-2018 онд жилд дунджаар 6.9 хувиар өргөжсөн ч хамгийн бага орлоготой 40% иргэдийн дундаж орлого ердөө 1 хувиар нэмэгдсэн байгаа нь хүртээмжтэй өсөлт сул байгаагийн илрэл юм. Монгол улсын хувьд 1998-2018 онуудын жилийн дундаж хүртээмжтэй өсөлтийг тооцоход 5.1 хувь байна.

Харин хүртээмжтэй өсөлтөд нөлөөлөгч хүчин зүйлсийн хувьд үнэлгээний голлох үр дүнгээс дурдвал хүртээмжтэй өсөлтөд инфляцын түвшин, орлогын дахин хуваарилалт, санхүүгийн гүнзгийрүүлэлт буюу хувийн хэвшилд олгосон дотоодын зээлийн ДНБ-д эзлэх хувь зэрэг үзүүлэлтүүд сөргөөр, гадаадын шууд хөрөнгө оруулалт болон гадаад худалдааны нээлттэй байдал зэрэг нь эергээр нөлөөлдөг байна. Тухайлбал, инфляцын нөлөөллийн коэффициент -0.03 бол орлогын дахин хуваарилалтын коэффициент -0.17 гарсан байна. Энэ нь эдгээр үзүүлэлт 1 нэгжээр өсөхөд хүртээмжтэй өсөлт тус хувиар буурах нөлөөтэйг харуулж байгаа юм. Харин хувийн хэвшилд олгосон дотоодын зээлийн ДНБ-д эзлэх хувь 10 хувиар өсөхөд хүртээмжтэй өсөлтийг 0.1 хувиар бууруулна гэсэн үр дүн гарсан. ГШХО-ын ДНБ-д

эзлэх хэмжээ болон гадаад худалдааны ДНБ-д эзлэх хувь 10 хувиар нэмэгдэх нь хүртээмжтэй өсөлтөд харгалзан 1.6 болон 0.1 хувийн эерэг нөлөө авчрахаар байна.

Иймд мөнгөний бодлогоор дамжуулан үнийн тогтвортой байдлыг хангах, манай оронтой төстэй бусад улсын туршлагыг судлан өөрт тохирсон орлогын дахин хуваарилалтын оновчтой бодлого боловсруулах нь хүртээмжтэй өсөлтийг хангахад чухал ач холбогдолтой байна. Цаашид ГШХО татах, гадаад худалдааны нээлттэй байдал болон эдийн засгийг дэмжих бодлогуудыг уялдуулах, тэдгээрийн хууль эрх зүй, татварын орчны зохицуулалтуудыг сайжруулах, мөн дунд, урт хугацаанд бусад орны жишгээр уул уурхайн бус экспортыг дэмжих урт хугацааны, тогтвортой бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Энэхүү судалгааг цаашид өрхийн түвшний микро тоон мэдээллийг ашиглан Монгол улсын хүртээмжтэй өсөлтийн нөхцөл байдлыг үнэлэх байдлаар өргөжүүлэн судлах боломжтой гэж үзэж байна.

Хавсралт

Хавсралт 1. Азийн орнуудын хүртээмжтэй өсөлтийн задаргаа

	Хүртээмжтэй өсөлт	Орлогын өсөлт	Орлогын тархалтын өсөлт
Хятад	8.2%	8.7%	-0.6%
Энэтхэг	0.0%	0.0%	0.0%
Индонез	2.9%	3.2%	-0.3%
Пакистан	1.5%	1.7%	-0.2%
Бангладеш	4.1%	4.1%	0.0%
Япон	0.4%	0.4%	0.0%
Филиппин	3.5%	3.1%	0.4%
Вьетнам	5.4%	5.4%	0.0%
Турк	3.1%	3.2%	-0.1%
Тайланд	3.9%	3.1%	0.8%
Солонгос	3.0%	2.9%	0.1%
Малайз	3.9%	3.3%	0.5%
Непал	2.9%	2.6%	0.2%
Казахстан	4.2%	3.7%	0.5%
Камбож	5.6%	6.1%	-0.4%
Тажикстан	0.0%	0.0%	0.0%
Лаос	4.9%	5.2%	-0.3%
Киргиз	4.5%	2.9%	1.6%
Сингапур	0.0%	0.0%	0.0%
Гүрж	6.4%	6.2%	0.1%
Монгол	5.0%	5.1%	-0.1%
Армен	7.6%	6.5%	1.1%

Хавсралт 2. Монгол Улсад хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүд ба хүртээмжтэй өсөлт

Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн хүрээнд Монгол Улсын Засгийн газар “Урт хугацааны хөгжлийн бодлогын эрхэм 9 зорилго”-ыг тодорхойлон ногоон хөгжил (Зорилго 6), эдийн засгийн хөгжил (Зорилго 4, 8, 9), нийгмийн хөгжлийн (Зорилго 2,3) үр дүнд бий болгосон баялгийг хүндээ хүргэж Монгол хүний сайн сайхан байдлыг дээшлүүлэхэд чиглэн ажиллахаар тусгасан байна.

Шинэ сэргэлтийн бодлого нь Монгол Улсын эдийн засгийн хараат бус, бие даасан байдлыг бэхжүүлэх, Коронавируст халдвар /КОВИД-19/-г цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөгжлийг хязгаарлагч хүчин зүйлийг цаг алдалгүй шийдвэрлэж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засаг, дэд бүтэц болон төрийн бүтээмжийг сайжруулахад чиглэсэн 10 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжих дунд хугацааны зорилтот хөтөлбөр юм.

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал нь улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, оюуны чадавхыг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэх зорилтыг тавьсан.

Тогтвортой хөгжлийн зорилт-2030 (SDG) нь нийгэм, эдийн засаг, байгаль орчин гэсэн гурван тулгуурт суурилан тогтвортой хөгжилд хүрэх дэлхийн нийтийн урт хугацааны бодлогын баримт бичиг бөгөөд Ядуурлыг бууруулах, Эрүүл мэндийг дэмжих, Чанартай боловсролыг дэмжих, Жендерийн эрх, тэгш байдлыг хангах, Эдийн засгийн өсөлт, баталгаат ажлын байрыг бий болгох, Инновац болон дэд бүтцийн нэмэгдүүлэх, Тэгш бус байдлыг бууруулах, Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах зэрэг хүртээмжтэй өсөлтийн үзүүлэлтүүдийг тусгажээ.

Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх **Үндэсний Тодорхойлсон хувь нэмэр (NDC)** эдийн засгийн гол салбаруудын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн нэгдсэн зорилт, арга хэмжээ мөн уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөлөл, эрсдэлийг бууруулахад чиглэсэн дасан зохицох арга хэмжээг нийгэм, эдийн засгийн эмзэг салбаруудаар тодорхойлов.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлд “Цар тахлаас үүдэлтэй хүндрэлийг даван туулж, эдийн засгийн сэргэлтийг дэмжих, өсөлтийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөв, мөнгө, санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх” тусгасан байна.

Хавсралт 3. Үнэлгээнд ашигласан хувьсагчдын тайлбар

3.1 Тоон мэдээллийн тайлбар, эх сурвалж

Үзүүлэлт	Хувьсагч	Нэгж	Тэмдэг	Эх сурвалж
Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт	Өмнөх жилийн өсөлт (2015 оноор зэрэгцүүлсэн)	Хувь	+	Дэлхийн банк
Инфляцын түвшин	ХҮИ-д суурилсан жилийн инфляц	Хувь	-	ОУВС
Орлогын дахин хуваарилалт	Татварын өмнөх ба дараах орлогод суурилсан жини коэффициентын зөрүү	нэгж	+/-	SWIID 8.0 өгөгдлийн сан
Санхүүгийн гүнзгийрэлт	Хувийн хэвшилд олгосон дотоодын зээлийн ДНБ-д эзлэх хувь	Хувь	+	ОУВС, Дэлхийн банк
ГШХО	ГШХО-ын ДНБ-д эзлэх хувь	Хувь	+	ОУВС, Дэлхийн банк
Худалдааны нээлттэй байдал	Гадаад худалдааны ДНБ-д эзлэх хувь	Хувь	+	Дэлхийн банк
Цэвэр хадгаламж	Нийт цэвэр хадгаламжийн ҮНО-д эзлэх хувь	Хувь	+	Дэлхийн банк

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

3.2 Хувьсагчдын тайлбар

Үзүүлэлт	Хувьсагчдын тоо	Дундаж	Тэмдэг
Нэг хүнд ногдох ДНБ-ий өсөлт	444	5.43	3.81
Инфляцын түвшин	457	5.52	6.03
Орлогын дахин хуваарилалт	382	3.79	3.79
Санхүүгийн гүнзгийрэлт	411	59.69	44.20
ГШХО	462	3.46	5.84
Худалдааны нээлттэй байдал	462	92.75	73.34
Цэвэр хадгаламж	456	14.40	10.40

Эх сурвалж: Судлаачийн нэгтгэл

Ашигласан материал

- Albanesi, S. (2007). Inflation and inequality. *Journal of Monetary Economics*, 54(4). [http://www.sciencedirect.com/science/article/pii/S0304-3932\(06\)00212-1](http://www.sciencedirect.com/science/article/pii/S0304-3932(06)00212-1)-ээс Гаргасан
- Alekhina, V., & Ganelli, G. (2020). Determinants of Inclusive growth in ASEAN. *IMF Working paper*, 20(118).
- Ali, Ifzal, & Son, H. (2007). Measuring Inclusive Growth. *Asian Development Review*, 24(No.1), 11-31.
- Ali, Ifzal, & Zhuang, J. (2007 оны July). Inclusive Growth toward a Prosperous Asia: Policy Implications. *ERD Working Paper series*(No.97).
- Anand, R., Mishra, S., & Peiris, S. J. (2013). Inclusive Growth: Measurement and Determinants. *IMF Working paper*, 13(135).
- Aoyagi, C., & Ganelli, G. (2015). Asia's Quest for Inclusive Growth Revisited. *Journal of Asian Economics*, 40(C), 29-46.
- Balakrishman, Chad, & Murtaza. (2013). The Elusive Quest for Inclusive Growth: Growth, Poverty, and Inequality in Asia. *IMF Working Paper 13/152*.
- Benabou, R. (2000 оны March). Unequal Societies: Income Distribution and the Social Contract. *American Economic Review*, 90(1), 96-129.
- Chandra, J., Kinda, S., Kochhar, T., Piao, S., & Schauer. (2016). Sharing the Growth Dividend: Analysis of Inequality in Asia. *IMF Working Paper No. 16/48*.
- Cœuré, B. (2012). What can monetary policy do about inequality? "Extreme Poverty and Human Rights, Fourth World Committee" event. ECB.
- Coibion, O., Gorodnichenko, Y., Kueng, L., & Silvia, J. (2012). Innocent Bystanders? Monetary Policy and. *IMF Working paper*.
- Dollar, D., & Kraay, A. (2003). Institutions, Trade, and Growth. *Journal of Monetary*, 50(1), 3-39.
- Gründler, K., & Scheuermeyer, P. (2018). Growth effects of inequality and redistribution: What are the transmission channels? *Journal of Macroeconomics*, 293(313).
- Kireyev, A., & Chen, J. (2017). Inclusive Growth Framework. *IMF working paper*, 17(127).
- Loungani, P., & Ostry, J. (2017). *The IMF's Work on Inequality: Bridging Research and Reality*. The IMF Blog: <https://blog-imfdirect.imf.org/2017/02/22/the-imfs-work-on-inequality>--ээс Гаргасан
- Loungani, P. (2017). Inclusive Growth and the IMF. *iMFdirect - The IMF Blog*. <https://blog-imfdirect.imf.org/2017/01/24/inclusive-growth-and-the-imf>.-ээс Гаргасан

- McKinsey. (2021). *The case for inclusive growth*. Mckinsey & Company. <https://www.mckinsey.com/industries/public-and-social-sector/our-insights/the-case-for-inclusive-growth>-ээс Гаргасан
- Nizam, R., Karim, Z. A., Rahman, A. A., & Sarmidi, T. (2020). Financial inclusiveness and economic growth: new evidence using a threshold regression analysis. *Economic research*, 33(1).
- Okun, M. (1975). Equality and Efficiency: The Big Tradeoff. <http://www.jstor.org/stable/10.7864/j.ctt13wztjk>-ээс Гаргасан
- Ostry, J. D., Berg, A., & Tsangarides, C. (2014 оны February). Redistribution, Inequality, and Growth. *IMF staff discussion note*.
- Ramey, G., & Ramey, V. (1995 оны December). Cross-Country Evidence on the Link Between Volatility and Growth. *The American Economic Review*, 85(5), 1138-1151.
- Ranieri, R., & Ramos, R. A. (2015). After All, What is Inclusive Growth? *International Policy Centre for Inclusive Growth*.
- Rauniyar, Ganesh, & Kanbur, R. (2010). Inclusive Development: Two papers on Conceptualization, Application, and the ADB Perspective. *Independent Evaluation Department, ADB*.
- Romer, C., & Romer, D. (1998 оны November). Monetary Policy and the Well-Being of the Poor. *National Bureau of Economic Research*.
- Ross, L. (2005). *Finance and Growth: Theory and Evidence* (Б. 1).
- Sun, Y., Ding, W., Yang, Z., Yang, G., & Du, J. (2020). Measuring China's regional inclusive green growth. *Science of the Total Environment*, 713.
- Thewissen, S. (2014 оны July). Is it the income distribution or redistribution that affects growth? *Socio-Economic Review*, 12(3), 545-571.
- Turnovsky, S., & Garcia-Penalosa, C. (2007). Growth, Income Inequality, and Fiscal Policy: What Are the Relevant Trade-offs? *Journal of Money, Credit and Banking*, 29(2-3), 369-394.
- Zhuang, J., Kanbur, R., & Rhee, C. (2014). Rising Inequality in Asia and Policy Implications.
- Д.Даваасүх. (2012). Хүртээмжтэй өсөлт. *Судалгааны ажил, Товхимол-8*.
- С.Билгүүнзул. (2019). Монгол улсын орлогын тэгш бус байдал. *Мөнгө баялаг санхүү сэтгүүл*, 19(7).
- Ч.Дэлгэржаргал, Ж.Арман, & Б.Арьяасүрэн. (2021). Хүртээмжтэй өсөлт. *Мөнгө, санхүү, баялаг*.